

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН
2022 ОНЫ 09 ДҮГЭЭР ХУРАЛДААН**

Аймгийн Засаг даргын Зөвлөлийн 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 09 дүгээр хуралдааныг 15 цаг 06 минутад Нутгийн удирдлагын ордны II давхрын хурлын танхимд хийж, Зөвлөлийн гишүүдийн 69.2 хувийн ирцтэй хуралдав.

Д/д	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	Төрийн дээд одон, медалиар шагнуулахаар ирүүлсэн иргэдийн материалыг хэлэлцүүлэх тухай	<p>ШИЙДВЭРЛЭСЭН нь:</p> <p>1. Аймаг, орон нутгийнхаа эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулан, санхүүгийн салбар болон нийгмийн даатгалын байгууллагад тасралтгүй 40 гаруй жил үр бүтээлтэй ажилласан Жамсрангийн Бугалжааг “Гавьяат эдийн засагч” цол тэмдгээр, худалдаа бэлтгэл, нийтийн хоол, байгаль орны салбар тасралтгүй 50 гаруй жил үр бүтээлтэй ажиллаж байгаа Пэрэнлэйн Тогтохбаатарыг “Худалдааны гавьяат ажилтан” цол тэмдгээр шагнуулахаар тодорхойлсон материалыг журмын дагуу шинэчлэн бүрдүүлж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт уламжлах;</p> <p>2. Аймаг, орон нутгийнхаа эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулан, боловсрол, эрүүл мэнд, барилга, тээвэр, санхүүгийн салбарын төр, хувийн хэвшлийн байгууллагад олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж байгаад гавьяаныхаа амралтад гарсан ахмад настнууд болон ажиллаж байгаа дор дурдсан нэр бүхий иргэдийг төрийн дээд одон, медальд тодорхойлсон материалыг Монголын ахмадын холбоо болон холбогдох яамдад уламжлан дэмжсэн санал авч Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт тус тус уламжлахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Б.Ганболд, тус хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Гантөмөр нарт үүрэг болгов.</p>
2	Жаргалант сумын 1 дүгээр цэцэрлэгийн төсөл сонгон шалгаруулалтын талаар танилцуулах тухай	<p>ШИЙДВЭРЛЭСЭН нь:</p> <p>1. Жаргалант сумын 1 дүгээр цэцэрлэгийн төсөл сонгон шалгаруулалтыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хэрхэн зохион байгуулбал үр дүнд хүрэх талаар гаргалгаа гаргаж, дараагийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхийг Хууль эрх зүйн хэлтсийн дарга Н.Ганзориг, Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газрын дарга Э.Дөлбадрал нарт үүрэг болгов.</p>
3	Эрүүл мэндийн салбарын 2022 оны эхний 5 сарын ажлын гүйцэтгэлийн тайлан хэлэлцүүлэх	<p>ШИЙДВЭРЛЭСЭН нь:</p> <p>1. Эрүүл мэндийн салбарын 2022 оны эхний 5 сарын ажлын гүйцэтгэлийн тайлан хэлэлцүүлэх явцад Зөвлөлийн гишүүдээс гарсан санал, зөвлөмжийг тусгаж, салбарын байгууллагууд болох Эрүүл мэндийн</p>

	тухай	даатгалын хэлтэс, Бүсийн оношлогоо, эмчилгээний төв, Зоонозын өвчин судлалын албаны тайланг нэгтгэн сайжруулж, нэгтгэсэн байдлаар дараагийн хурлаар хэлэлцүүлэхийг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга ахлах мэргэжилтэн С.Дорж, Эрүүл мэндийн газрын дарга Ц.Мягмарсүрэн нарт үүрэг болгов.
4	Боловсролын байгууллагын 2021-2022 оны хичээлийн жилийн ажлын тайлан хэлэлцүүлэх тухай	ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Ерөнхий боловсролын сургуулийн 2021-2022 оны хичээлийн жил дуусаж, төгсөлт хийсний дараагаар VII дугаар сард Боловсрол, шинжлэх ухааны газрын ерөнхий гүйцэтгэл гарах тул 2022-2023 оны шинэ хичээлийн жилийн тайлангийн хамтаар дараагийн хурлаар хэлэлцүүлэх талаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд албан бичиг хүргүүлэхийг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Б.Даваадорж, Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга Б.Алтангэрэл нарт үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР